



ДААТГАЛ
SINCE 1994

2018 | ЖИЛИЙН
ТАИЛАН

Хүчтэй. Хамтдаа.

АГУУЛГА

Ард Даатгалын амжилтын товчоон	5
Хувьцааны арилжааны мэдээ	9
ТУЗ-ын даргын мэндчилгээ	13
Компанийн засаглалын тайлан	17
2018 оны эдийн засгийн өсөлт, нийгэм улс төрийн байдал	37
2018 оны даатгалын зах зээлийн өөрчлөлт	41
Гүйцэтгэх захирлын илгээлт	47
Даатгалын үйл ажиллагааны тайлан	53
Нөхөн төлбөрийн тайлан	57
Эрсдэлийн шинжилгээ	63
Эрсдэлийн хорооны тайлан	69
Нийгмийн хариуцлага	71
Хүний нөөц	75
2019 оны төсөөлөл, төлөвлөгөө	77
2018 оны аудитлагдсан санхүүгийн тайлан	81

Ард даатгалын
амжилтын товчоон

АРД ДААТГАЛЫН
АМЖИЛТЫН ТОВЧООН

Ард даатгалын
амжилтын товчоон



Ногдол ашиг

2017 оны цэвэр ашгийн 50 хувиар буюу 562 сая төгрөг



IPO хийх зөвшөөрөл

2019 оны 8 сарын 29-ний өдөр СЗХ-оос IPO хийх зөвшөөрөл гарч хувьцааны захиалга 32.7 хувь давж биелснээр хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй нээлттэй хувьцаат даатгалын компани болсон.



Хувьцаа эзэмшигчдийн хурал

Нээлттэй хувьцаат компани болсноор 2018 оны 12 сарын 1-ний өдөр ээлжит бус ХЭХ-ыг зарлан хуралдуулсан.



ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Ч.Ганзориг, Б.Золбоо нарыг ердийн гишүүн З.Ариун, Б.Болорчимэг нарыг хараат бус гишүүнээр томилсон.



Ard Medicare

Олон улсын эрүүл мэндийн даатгалын шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлж эхэлсэн.

2018

Түүхэн жил 2018

Нээлттэй хувьцаат компани болж компанийн шинэ хуудсыг нээсэн төдийгүй санхүүгийн үзүүлэлтийн хувьд түүхэн дээд амжилтуудыг гаргасан байна.


Хувьцааны
Мэдээ

ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ
МЭДЭЭ



Хувьцааны
Мэдээ

2018/12/31 хаалтын ханш	770 (+10.0%)
Зах зээлийн үнэлгээ:	19.25 тэрбум төгрөг
11 долоо хоногт:	700-920 (+31,4%)
Арилжаалагдсан хувьцааны тоо:	3.17 сая ширхэг
Арилжаалагдсан нийт дүн:	2.49 тэрбум төгрөг
Өдрийн дундаж арилжаа:	39.54 сая төгрөг

Хувьцааны ханш



Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл




Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
(2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар)

Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо /мянга/	Эзлэх хувь
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	16,789	67.2%
Би Ди Сек ҮЦК ХК	1,589	6.3%
Энержи Интернэйшнл Капитал ХХК	821	3.3%
Ард Лайф ХХК	373	1.5%
Ч.Амарбаатар	266	1.1%
Бусад	5,164	20.7%
НИЙТ ДҮН	25,000	100%

2018/10/1-2018/12/31 хоорондын арилжааны тайлан

Нийт арилжааны дүн	2,574,061,104
700-750 хооронд	998,328,819
750-800 хооронд	817,403,290
800-901 хооронд	758,328,995
Өдрийн дундаж арилжааны дүн	39,540,000
Арилжааны дундаж үнэ	784

Хувьцаа эзэмшигчдийн тоо



ТУЗ-ИЙН ДАРГЫН
МЭНДЧИЛГЭЭ



Чулууны Ганхуяг

ТУЗ-ийн дарга

Мэргэжил: **Эдийн засагч, банк санхүүгийн менежмент**

Давхар албан тушаал: **“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн гүйцэтгэх захирал**

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагч даатгуулагчид болон хамтран зүтгэгчид та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. 2018 он бол бидний хувьд компанийн нэн шинэ түүхийн эхлэлийг тавьсан ерөөлтэй, өгөөжтэй жил байлаа.

Бид амласан ёсоороо 2018 оны сүүлийн хагаст Ард Даатгалын IPO-г хийж, компанийн нийт хувьцааны 30 хувийг 5.25 тэрбум төгрөгөөр олон нийтэд санал болгосон. Үүний үр дүнд Ард Даатгал хамгийн олон хүний өмчийн даатгалын компани болж чадсан. Тиймээ, бид одоо 1,600 гаруй хувьцаа эзэмшигчтэй боллоо. Мэргэжлийн байгууллагуудын хийсэн үнэлгээ 1,200 орчим төгрөгөөр тогтсон ч манай хувьцаа 2018 оны эцэст 770 төгрөгөөр хаагдаж, цаашид өсөн дэвжих өргөн боломж агуулагдсаар байгааг нотоллоо. 770 төгрөгийн ханш нь Ард Санхүүгийн Нэгдлийн үнэлгээнд эерэг 3.4 тэрбум төгрөгийн нөлөөлөл авчирлаа. Ард Даатгал үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөж, 2018 онд хамгийн өндөр хураамжийн болон хөрөнгө оруулалтын орлого бүрэлдүүлж чадсан юм. 2019 онд Ард Даатгал үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ой тохиож байна. Бид энэ ойгоо ажил хөдөлмөрийн өндөр амжилтаар угтаж,

та бүгдтэйгээ хамт тэмдэглэхээр зэхэж байна. Бид даатгалын үйлчилгээг танд цахимаар ойртуулж, хүртээмжийг улам нэмэгдүүлж, зах зээлд ашиг орлогоороо манлайлах зорилго дэвшүүлж байна.

Ард Даатгал ХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр гарч нээлттэй компани болсон. 2018 оны 4 сард хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн ТУЗ-ийн бүтцийг нээлттэй компани болохтой холбогдуулан өргөжүүлж, 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар дүрэмд өөрчлөлт оруулан баталсан. Үүний дагуу ТУЗ нь хараат буюу ердийн гишүүний тоог нэмэгдүүлэн Ард Санхүүгийн Нэгдлийн харьяа компанийн удирдлагууд болох Ч.Ганзориг, Б.Золбоо нарыг ТУЗ-д нэр дэвшүүлэн сонгосон. Мөн хараат бус гишүүдэд З.Ариун, Б.Болорчимэг нарыг нэр дэвшүүлэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас санал нэгтгэйгээр томилсон билээ. Оны сүүлээр ТУЗ-ийн ердийн гишүүн Антони Хоброу нь ВенчерсУан компани хувьцаагаа зарсантай холбогдуулан ТУЗ-өөс чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн бөгөөд ТУЗ 2018 оны 9 сарын хурлаараа хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

2018 оны 12 сарын 1-ний өдөр хуралдсан ТУЗ-ийн ээлжит хурлаас ТУЗ-ийн хараат бус түр гишүүнд

МостФинтек ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Оргилыг нэр дэвшүүлэн, санал нэгтгэйгээр сонгосон. Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн, анхны нээлттэй даатгалын компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдсон С.Оргилд цаашдын ажилд нь амжилт хүсье.

2018 оны хамгийн анхны ТУЗ-ийн хурлаас компани 2017 оны цэвэр ашгаас 50 хувийг нь ногдол ашгаар хуваарилах шийдвэр гаргаж, жил бүр ашгийнхаа 30-50 хувийг ногдолашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчиддээ олгож байх Ногдол ашгийн журмыг баталж, СЗХ болон Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлсэн билээ. Цаашид энэ жишгийг барьж, хувьцаа эзэмшигчиддээ жил бүр ногдол ашиг тарааж, өгөөжийг хөрөнгө оруулагчиддаа тэгш хүртээх бодлого барьж ажиллана.

2018 оныг бид амжилттай үдэж, 13 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж түүхэндээ хамгийн өндөр борлуулалтыг үзүүлж чадлаа.

2018 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилах шийдвэрийг ТУЗ-ийн 2019 оны анхны хурлаас шийдвэрлэж, эхний хагас жилдээ багтан хөрөнгө оруулагчиддаа өгөөжийг нь хүртээнэ.

Олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон нь 2019 онд бидний өмнөө тавьсан зорилт, борлуулалтад үлэмж нөлөө үзүүлнэ гэдэгт бид итгэлтэй байгаа бөгөөд Ард Санхүүгийн Нэгдлийн бусад компаниудын харилцагчдад мөн даатгалын үйлчилгээг давхар санал болгож, огтлолцоо борлуулалтыг нэгдлийн бүхий л түвшинд дэмжин ажиллана. Үүнээс гадна бид цахим шилжилтийг тууштай хэрэгжүүлж, даатгалын үйлчилгээг цахимжуулах, Ард Апп дээр даатгалын бүтээгдэхүүн худалдан авах боломжийг нээж, зах зээлд цоо шинэ боломжуудыг бий болгон ажиллах үүргийг компанийн гүйцэтгэх удирдлагад даалган хариуцуулаа. 2019 онд хөдөө орон нутаг, аймгийн төвүүд, алслагдсан сумдад даатгалын үйлчилгээг иж бүрнээр хүргэхэд бидний өнгөрсөн хугацаанд бий болгосон дэд бүтэц ажиллахад бэлэн болоод байна. Ард Даатгалын 100 гаруй ажиллагсад дээр нэмэгдээд Монгол Шуудангийн салбарууд, хөдөөгийн хадгаламж зээлийн хоршоод, Ард Санхүүгийн Нэгдлийн хөдөө орон нутаг дахь төлөөлөгчид даатгалын борлуулалтыг хийхэд тууштай дэмжин ажиллана.

Ингээд Хөрөнгө Оруулагч Үндэстний салшгүй хэсэг болох хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагч, хамтран ажиллагсад та бүхэндээ 2018 оны турш хамт байсанд чин сэтгэлийн талархал илэрхийлж, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Handwritten Mongolian calligraphy in black ink, featuring two vertical columns of stylized characters.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН
ТАЙЛАН

Large, stylized handwritten Mongolian calligraphy in grey ink, featuring two vertical columns of characters. The bottom portion of the calligraphy is filled with a detailed architectural illustration of a traditional building.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Ард Даатгал ХК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. 2018 онд хувьцаа эзэмшигчдийн хурал 2 удаа хуралдсан байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 сарын 20-ний өдөр хуралдаж, 3 сарын 30-ны өдөр ТУЗ-ийн IPO хийх тухай шийдвэрийг баталгаажуулан, ТУЗ-ийн гишүүдийг томилох, компанийн хувьцааг хуваах, нээлттэй компанийн ТУЗ-ийн шаардлагад нийцүүлэн ТУЗ-ийн бүтцийг шинэчлэн батлах, ТУЗ-ийн 2018 оны төсвийг батлах зэрэг шийдвэрүүдийг гаргасан билээ.

Огноо	Ирц	Шийдвэрлэсэн асуудлууд
2018.4.20	100%	1. 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох 3. Компанийн хувьцааг хуваах 4. Нээлттэй компани болох, 5.25 тэрбум төгрөгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр гаргаж олон нийтэд арилжих 5. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтцийг шинэчлэн батлах 6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны төсвийг батлах
2018.12.1	74.25%	1. Дүрмийн санг нэмэгдүүлэх 2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах

Энэхүү шийдвэрийн дагуу компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон менежментийн баг хувьцаат компани болохтой холбоотой ажилд ханцуй шамлан орсон бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид IPO хийх зөвшөөрлийг авахаар 2018 оны 5 сарын 14-ний өдөр бичиг баримтаа бүрдүүлэн өгсөн.

СЗХ болон МХБ-ээс Ард Даатгал компанийг нээлттэй хувьцаат компани болох, хувьцаагаа хөрөнгийн зах зээлд гарган олон нийтэд нээлттэй худалдах зөвшөөрлийг олгосны дараа 2018 оны 9 сарын 17-ны өдрөөс 26-ны өдрийн хооронд хувьцааны анхдагч арилжааны захиалгыг хөрөнгө оруулагчдаас хүлээн авч, 2018 оны 10 сарын 1-ний өдрөөс Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцааны хоёрдогч арилжааг эхлүүлсэн байна.

Ард Даатгалын хувьцааны анхдагч зах зээлийн

арилжаанд нийт 1,359 хөрөнгө оруулагч оролцсон бол, оны эцсээр хувьцаа эзэмшигчдийн тоо 1,649 болон нэмэгдэж, Монголын хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй даатгалын компани боллоо.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 10 сарын 11-ний өдрийн хурлаас IPO амжилттай хийснээс хойш анхны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар тогтсон бөгөөд 12 сарын 1-ний өдөр Туушин зочид буудлын байранд хурал амжилттай болж өнгөрлөө. Хурал нийт 74.25 хувийн ирцтэй хүчин төгөлдөрт тооцож, нийт 131 хувьцаа эзэмшигчид хуралд биечлэн оролцсон. Тус хурлаар компанийн дүрмийн сан нэмэгдсэнийг албан ёсоор баталгаажуулан, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулан санал нэгтэй баталсан билээ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

2018 оны 4 сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн дүрэмд өөрчлөлт оруулан ТУЗ-ийг 7 гишүүнтэй байсныг 9 болгон өргөжүүлж шийдвэрлэсэн бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д заасны дагуу ". . . гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна" гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 5 ердийн, 4 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. ТУЗ-ийн даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн гүйцэтгэх захирал Чулууны Ганхуяг ажиллаж байна.

2018 оны 3 сарын 30-ны өдөр хуралдсан ТУЗ-ийн ээлжит хуралд Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооноос ТУЗ-ийн хараат гишүүнд З.Ариун болон Б.Болорчимэг нарыг санал нэгтгэйгээр нэр дэвшүүлж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан томилуулахаар шийдвэрлэсэн.

2018 оны 4 сард хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн

хараат буюу ердийн гишүүнээр гол хувьцаа эзэмшигч Ард Санхүүгийн Нэгдлийн зүгээс Ч.Ганзориг, Б.Золбоо нарыг нэр дэвшүүлж томилсон бөгөөд хараат бус гишүүнээр Б.Болорчимэг, З.Ариун нарыг нэр дэвшүүлэн томилсон. Ч.Ганзориг болон Б.Золбоо нар нь Нэгдлийн харъяа компаниудад үүрэгт ажил гүйцэтгэдэг бөгөөд Ард Даатгалын ТУЗ-ийн эгнээнд нэгдэн, компанийн үйл ажиллагааг бодлогын хүрээнд удирдан чиглүүлж манлайлах үүргийг давхар гүйцэтгэхээр боллоо.

2018 оны 9 сард ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байсан Антони Хоброу Венчерс Уан компани Ард Санхүүгийн Нэгдэл дэх хувьцаагаа худалдсантай холбогдуулан өөрийн саналаар ТУЗ-өөс чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн. 2018 оны 10 сард хуралдсан ТУЗ-ийн ээлжит хурлаар А.Хоброугийн хүсэлтийг хүлээн авч, үүрэгт ажлаас нь чөлөөлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хараат бус гишүүний сонгууль явуулахаар тогтсон.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх зарыг олон нийтэд түгээсэн боловч нэр дэвших хүсэлт ирээгүйтэй холбоотой сонгууль явагдаагүй бөгөөд 2018 оны 12 сард хуралдсан ТУЗ-ийн ээлжит хурлаас ТУЗ-ийн хараат бус гишүүнд С.Оргилыг Ард Санхүүгийн Нэгдлийн зүгээс нэр дэвшүүлж, түр гишүүнээр томилсон. С.Оргил нь банк санхүүгийн байгууллагад технологийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр олон жил ажилласан туршлагатай нэгэн бөгөөд Мост Финтек ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг юм.

ТУЗ-ийн дэргэд Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Эрсдэл, хөрөнгө

орүүлалтын хороо, Аудитын хороо тогтмол ажиллаж, жилийн турш ТУЗ-ийн хурлын өмнө хурлаар шийдвэрлэх асуудал бүрээр урьдчилсан хэлэлцүүлэг явуулж, хорооны саналыг ТУЗ-д танилцуулж шийдвэр гаргуулан ажиллалаа.

ТУЗ-ийн нийт гишүүд компанийн засаглалын сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлэн зөвшөөрөл авсан болно.



Чулууны Ганхуяг

ТУЗ-ийн дарга

Боловсролын байдал

Ч.Ганхуяг нь 1991 онд Нийслэлийн 10 жилийн 23-р дунд сургуулийг төгссөн. 1997 онд Унгар Улсын

Ажлын туршлага

Монголын Хөрөнгийн Биржээс 1991 онд хөдөлмөрийн гараагаа эхэлсэн тэрээр 1997 оноос Монгол банкинд хянан шалгагчаар ажиллаж байсан. 1998 онд НҮБ-ын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр Санхүүгийн менежерээр шалгаран ажиллаж байгаад 1999 онд Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Хөгжлийн Алтан Сан (ХАС)-г байгуулан Гүйцэтгэх захирлаар нь томилогдсон юм. ХАС нь бичил зээлийн үйл ажиллагааг амжилттай явуулсаар 2001 онд Говийн Эхлэл ББСБ-тай нэгдэж, өнөөгийн ХасБанк байгуулагдсан юм. Ч.Ганхуяг нь ХасБанкийг байгуулагдсан цагаас хойш 2009 оныг хүртэл Гүйцэтгэх захирлаар ажилласан бөгөөд 2009-2010 онд ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх захирлаар, 2009 онд Монгол улсын ерөнхий сайд С.Батболдын эдийн засаг, хөгжлийн асуудлын зөвлөхөөр, 2010-2012 онд Монгол Улсын Сангийн Яамны дэд сайдаар тус тус томилогдон ажиллаж байв. Тэрээр Унгар улсын өргөмжит консул, Монголын Эдийн Засгийн Форумын

Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг бакалаврын зэрэгтэй төгссөн.

санаачлагч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Монголын Оюутны Холбооны Ерөнхийлөгч, Олон Улсын Бичил Санхүүгийн Төвийн УЗ-ийн гишүүн, Улаанбаатар Глобал Шейперс нийгэмлэгийн удирдагч, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Ерөнхийлөгч гэх мэт албан тушаал хашиж байснаас гадна Монгол Улсад анхлан хадгаламж зээлийн хоршооны хөдөлгөөнийг 1990-ээд оны сүүлээр эхлүүлж, СИДАН ХЗХ-ны Удирдах Зөвлөлийн даргаар ажиллаж байжээ. 2009 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумаас түүнийг Дэлхийн Залуу Манлайлагчаар өргөмжилсөн байна. Ч.Ганхуяг нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн үүсгэн байгуулагчдын нэг төдийгүй, тус компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Мөн тэрээр Ард Даатгал ХК, Ард Кредит ББСБ ХК, Ард Менежмент ХХК, Ард Секюритиз ҮЦК ХХК, И Ай Ти ХХК, Ард Лайф ХХК, Крипто Үндэстэн ХХК, Жинст Увс ХК, Акела Секюрити ХХК, ТэнГэр Системс компаниудын ТУЗ-ийн дарга, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр тус тус ажиллаж байна.



Одончимэдийн Одбаяр

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсролын байдал

О.Одбаяр нь 1984 онд Нийслэлийн 10 жилийн 13-р дунд сургуулийг төгссөн. Мөн тэрээр 1984-1988 онд Украин Улсын Киев хотын Багшийн Их Сургуулийг багшийн мэргэжлээр, 1996-1997 онд АНУ-ын Флоридагийн Техникийн Их Сургуулийг олон улсын эдийн засагч

Ажлын туршлага

Тэрээр 1988-1992 онд Монгол Улсын Их Сургуульд багшаар, 2000-2002 онд Монгол-Хятадын хамтарсан "Си Эм Эйч" төрийн өмчит компанийн Монголын талын Гүйцэтгэх захирлаар, 2002-2004 онд "МИАТ" ХК-ийн Бээжин дэх төлөөлөгчөөр, 2005-2010 оны хооронд Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Атташе, Гуравдугаар нарийн бичгийн даргаар, 2010-2012 оны хооронд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөхөөр, 2012 онд "Чингис Хаан зочид буудал цогцолбор" ХХК-

мэргэжлээр, 1997-2000 онд "Отгонтэнгэр" Их Сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 2017-2018 онд АНУ-ын Бостон хотын Харвардын Их Сургуулийг удирдлагын чиглэлээр тус тус суралцаж төгссөн.

ийн Гүйцэтгэх захирал, "Алтай Холдинг" ХХК-ийн дэд ерөнхийлөгчөөр, 2016 оноос "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Бизнес хөгжил эрхэлсэн дэд захирал, "Эрдэнэс Стийл" ХХК, "Шивээ-Овоо" ХК-ийн ТУЗ-ийн дарга, "Гашуун Сухайт Автозам" ХХК, "Арева Монгол" ХХК, Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ард Кредит ББСБ ХК, Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүний албан тушаалыг тус тус хашиж байна.



Галбадрахын Цогбадрах

ТУЗ-ийн ердийн гишүүн

Боловсролын байдал

Г.Цогбадрах нь 1992 онд Нийслэлийн 10 жилийн 33-р дунд сургуулийг төгссөн. 1997 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг санхүүгийн менежмент, банкны эдийн засагч мэргэжлээр, 2010 онд АНУ-ын Лос Анжелес дэх Үндэсний их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн.

Ажлын туршлага

Г.Цогбадрах нь 1996-1997 онд Голомт банкинд гадаад төлбөр тооцооны нягтлан бодогчоор, 1997-1999 онд Дунай ХХК-д менежерээр, 2000 онд Хөгжлийн Алтан Сан ББСБ-ын салбарын бүсийн захирлаар тус тус ажиллаж байсан. Мөн тэрээр 2008 он хүртэл Хас банкинд Дотоод аудит, Салбарын удирдлага, Санхүү бүртгэл, Хөрөнгө зохицуулалтын газрын захирлаар, 2010-2011 онд Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирлаар, 2011-2014 онд Тэнгэр Даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллажээ. Г.Цогбадрах 2005 оноос Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ард Секюритиз ҮЦК ХХК, Ард Менежмент ХХК-иудын, 2016 оноос Хөрөнгө оруулагч үндэстэн ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. 2017 оноос одоог хүртэл Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлаар болон ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.



Батбилэгийн Золбоо

ТУЗ-ийн ердийн гишүүн

Боловсролын байдал

Б.Золбоо нь 2012 онд ОХУ-ын Элчин сайдын яамны 14-р сургуулийг төгссөн. 2012-2013 оны хооронд Санхүү эдийн засгийн их сургуульд олон улсын мэргэшсэн нягтлан бодогч (ACCA) мэргэжлээр суралцсан. 2016 онд АНУ-ын Нью Йорк муж дахь Plattsburgh College-ийг санхүү, эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгсжээ. Суралцаж байх үедээ, Б.Золбоо нь J.P. Morgan-ий харьяа компани болох Primary Insight, FINRA итгэмжлэгдсэн брокерын Darwood Associates зэрэг компаниудад дадлагажуулах хөтөлбөрүүд, туршлага судлах болон ажилд бэлтгэх сургалтуудад хамрагдсан.

Ажлын туршлага

Б.Золбоо 2016-2017 оны хооронд Ард Секюритиз ҮЦК ХХК-д, 2017 оноос Ард Менежмент ХХК-д хөрөнгө оруулалтын шинжээчээр тус тус ажиллаж байв. 2018 онд Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон өнөөг хүртэл ажиллаж байгаа.



Чулууны Ганзориг

ТУЗ-ийн ердийн гишүүн

Боловсролын байдал

Ч.Ганзориг нь 2004 онд Нийслэлийн 10 жилийн 23-р дунд сургуулийг төгссөн. Мөн тэрээр 2005-2007 онд Шанхайн их сургуулийн Хятад хэлний ангийг, 2007-2010 онд Унгар улсын Будапешт хотын Корвинусын их сургуулийг бизнес менежментийн бакалавр зэрэгтэй төгссөн.

Ажлын туршлага

Ч.Ганзориг нь арван жилийн сургуулиа төгссөн даруйдаа ажлын гараагаа эхэлж, ХасБанкны тооцооны төвийн харилцагчийн үйлчилгээний ажилтнаар 1 жилийн турш ажиллаж, банк санхүүгийн салбарт туршлагажиж эхэлсэн билээ. Мөн түүнчлэн оюутан байх үедээ ТэнГэр Санхүүгийн Нэгдэл, Тэнгэр Даатгал зэрэг байгууллагуудад сайн дурын дадлагын ажил хийж байсан туршлагатай бөгөөд Унгар улсын Wallis Asset Management гэх хөрөнгө оруулалтын компанид их сургуулийн дадлагын ажлаа хийсэн. 2010-2012 оны хооронд Ард Секюритиз ҮЦК ХХК-д хөрөнгө оруулалтын шинжээчээр, 2012-2013 оны хооронд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д хөрөнгө оруулалтын мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан туршлагатай. Ард Кредит ББСБ-ын үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг нь 2013 оны 6 сараас өнөөг хүртэл Ард Кредит ББСБ ХК-д Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байгаа бөгөөд тус компанийн хөрөнгө оруулагчдын нэг юм. Мөн тэрээр Ард Секюритиз ҮЦК ХХК, Вайлд Дижитал Аженси болон Дуулиан 2020 ТББ зэрэг байгууллагуудын ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна. 2018 оны 4 сарын 19-ний өдрөөс Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.



Булганы Гантулга

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсролын байдал

Б.Гантулга нь 1999 онд Нийслэлийн 20-р дунд сургуулийг төгссөн. Тэрээр ОХУ-ын Москва хот дахь Г.В.Плехановын нэрэмжит Эдийн засгийн академид суралцан 2003 онд эдийн засгийн бакалаврын зэрэгтэй төгссөн.

Ажлын туршлага

Б.Гантулга 2004-2008 оны хооронд ХасБанкинд Маркетингийн газрын захирлаар, 2009-2011 онд Моннис Групп ХХК-д Дэд захирлаар тус тус ажиллаж байв. 2012 оноос Ананс аксис ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан бөгөөд 2014 онд Сүү ХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон. 2015 онд Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байгаад 2019 оны 2 сараас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн.



Зоригтын Ариун

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсролын байдал

2005 онд ОХУ-ын Элчин сайдын яамны 14-р сургуулийг төгссөн. 2006-2010 оны хооронд АНУ-ын Индиана муж дах Валпарайсогийн Их сургуульд

Бизнесийн менежментийн бакалавраар суралцжээ. 2014 онд Сингапур Улсын INSEAD их сургуульд Бизнесийн удирдлагаар магистрын зэрэг хамгаалсан.

Ажлын туршлага

2011 оноос Одод ХХК-д Бизнес хариуцсан менежерээр ажилласан. 2010-2012 оны хооронд Улаанбаатар хот дахь Америк сургуульд Сурагчдын үйлчилгээний менежерээр ажиллаж байв. 2012-2013 оны хооронд тус сургуульдаа бизнес хариуцсан менежерийн албан тушаалд томилогдон ажиллажээ. Тэрээр 2013 онд магистрын зэрэг хамгаалахаар

Сингапур улсыг зорьсон. Ийнхүү магистрын зэргээ амжилттай хамгаалж 2016 оноос Улаанбаатар хот дахь Америк сургуульд зөвлөх багшаар үргэлжлүүлэн ажиллах болжээ. 2018 оноос эхлэн Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.



Баатарзоригтын Болорчимэг

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсролын байдал

Дорнод аймгийн Хан-Уул цогцолбор сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн. 2012 онд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийг Монгол-Англи хэлний багш мэргэжлээр, Хэвлэлийн хүрээлэнд

сэтгүүлч мэргэжлээр суралцан төгссөн. 2016 онд Хүмүүнлэгийн ухааны их сургуульд Бизнесийн удирдлагаар магистрын зэрэг хамгаалжээ.

Ажлын туршлага

Б.Болорчимэг нь “Шинэ дэлхий” телевизээс ажлын гараагаа эхлүүлжээ. Тэрээр тус телевизэд 2012-2014 оныг хүртэл, MNC телевизэд 2014-2016 оны хооронд сэтгүүлч, хөтлөгчөөр ажилласан. 2016 оноос хойш NTV телевизэд сэтгүүлч, редактораар ажиллаж байна.

Тэрээр мөн MLC Training ХХК-д сургагч багшаар ажилладаг билээ. 2018 оноос эхлэн Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.



Сүхдоржийн Оргил

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсролын байдал

С.Оргил нь 1998 онд Нийслэлийн 10 жилийн 23-р дунд сургуулийг төгссөн. 1998-2000 оны хооронд Колорадогийн их сургуулийн Улаанбаатар дахь салбарт суралцаж байв. 2001-2002 онд Австралийн

Сидней хотод байрлах "AlphaBeta" коллежид, 2002-2006 онд Сиднейн технологийн их сургуульд тус тус суралцаж Программ хангамжийн инженерийн мэргэжлийг эзэмшжээ.

Ажлын туршлага

С.Оргил 2006 оноос хойш МОСТ Өртөө ХХК-д ажиллаж буй бөгөөд 2007-2009 онд Гаалийн Ерөнхий Газарт МХТ/Худалдан авалт хариуцсан мэргэжилтнээр давхар ажиллаж байв. МОСТ ПСП ХХК-д 2009-2012 оны хооронд Ерөнхий захирлын албан тушаалыг хашиж байсан ба 2012 оноос хойш

тус компанийн Үйл ажиллагаа хариуцсан захирлаар, 2014 оноос ПостКейр ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж буй. 2018 оны 12 сарын 13-нд Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилогдсон.

ТУЗ-ийн хурал

2018 онд компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь нийт 5 удаа хуралдаж, 4 удаагийн ээлжит болон 1 удаагийн ээлжит бус хурлыг хийж, цаг үеийн болон тулгамдсан асуудлуудаар шийдвэр гаргаж ажиллалаа.

ТУЗ-ийн хурал, огноо, ирц, гаргасан шийдвэрүүд

Огноо	Ирц	Шийдвэрлэсэн асуудлууд
2018.3.30	80%	<ol style="list-style-type: none"> 1. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр томилох 2. Хувьцаа эзэмшигчдэд цэвэр ашгийн 50 хувиар ногдол ашгийг олгох 3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2018 оны 4 сарын 25-ны өдөр хуралдуулах 4. Заавар, журам, бодлогын баримт бичиг батлах 5. Итгэлцлийн үйлчилгээнд хөрөнгө байршуулах 6. Компанийн хувьцаа худалдах 7. IPO гаргах
2018.6.15	78%	<ol style="list-style-type: none"> 1. ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийг шинэчлэн томилох 2. Батс Өргөө ХХК-ийг шүүхэд нэхэмжлэлийг өгч, асуудлыг шийдвэрлэх 3. Централ тауэрын шинэ салбарын нээлттэй зэрэгцүүлэн IPO-хувьцаа гаргах тухай зар сурталчилгааг хийх 4. Үл хөдлөх хөрөнгийг санхүүгийн түрээсийн гэрээгээр бусдын эзэмшил, ашиглалтанд шилжүүлэх 5. ТУЗ-ийн гишүүдийн 2017 оны урамшууллыг олгох 6. Гүйцэтгэх захирлын 2017 оны гүйцэтгэл, урамшуулал болон 2018 оны ажлын төлөвлөгөөг Засаглалын хорооны гишүүд рүү мэйлээр илгээж, ажлын шугамаар батлах

Огноо	Ирц	Шийдвэрлэсэн асуудлууд
2018.9.4	89%	<ol style="list-style-type: none"> 1. Ажиллагсдад хувьцааны борлуулалтын дүнгээс хоёр хувийн урамшуулал олгох 2. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн таван хувьтай тэнцэхүйц дүнгээр ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг, ажлын хэсгийн гишүүдэд урамшуулал олгох (Татан төвлөрүүлэх үйл ажиллагаа амжилттай хэрэгжсэн тохиолдолд)
2018.10.11	78%	<ol style="list-style-type: none"> 1. Дүрмийн санг олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 1.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 5 тэрбум төгрөг болгох 2. Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөс “Нэмж төлөгдсөн капитал” дансанд бичигдэх 3.75 тэрбум төгрөгөөс IPO-той холбоотой шууд зардлууд болох 0.47 тэрбум төгрөг хасч бүртгэх 3. IPO амжилттай болсонтой холбоотойгоор ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, ажиллагсад татан төвлөрүүлсэн хөрөнгийн 5 хувьтай тэнцэх урамшуулал хувьцаагаар олгох 4. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс компанийн бонд, итгэлцлийн үйлчилгээ, банкны хадгаламжуудад хөрөнгө оруулалт хийх 5. Нээлттэй хувьцаат компани болсонтой холбогдон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 сарын 1-ний өдөр хуралдуулах
2018.12.13	67%	<ol style="list-style-type: none"> 1. МОСТ Финтек ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал С.Оргилыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилох 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргаар Э.Гэрэлчимэгийг томилох 3. 2019 оны төлөвлөгөө, төсвийг батлах 4. 2019 оны ТУЗ-ийн хурлын хуваарийг дахин боловсруулах, эчнээ санал хураах 5. Хөндлөнгийн аудитын байгууллагаар Далай ван ХХК-ийг сонгох 6. Гүйцэтгэх захирлын 2019 оны үйл ажиллагааны KPI гишүүд рүү илгээж санал авч, эчнээгээр батлах

ТУЗ-ийн Хороодын хуралдсан байдал

Хороо, хорооны гишүүд	Шийдвэрлэсэн асуудлууд
Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо 2018.3.30	<ol style="list-style-type: none"> 1. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай З.Ариун Б.Болорчимэг 2. Урамшууллын журмын тухай 3. Гүйцэтгэх захирлын KPI, хөдөлмөрийн гэрээний сунгалт
Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо 2018.9.04	<ol style="list-style-type: none"> 1. ХК болсонтой холбоотой үйл ажиллагаандаа мөрдөх журам зааврыг батлах 2. IPO амжилттай явуулсантай холбоотой урамшууллыг батлах 3. ТУЗ-ийн ердийн гишүүн Антони Хоброуг чөлөөлөх, шинээр ердийн гишүүнд нэр дэвшүүлэх санал оруулах тухай
Эрсдэл хөрөнгө оруулалтын хороо 2018.3.30	<ol style="list-style-type: none"> 1. Хөрөнгө оруулалтын тайлан 2. Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай 3. Ногдол ашиг хуваарилах тухай 4. Хөрөнгийн биржид бүртгүүлэх ажлын явц 5. Эрсдэлийн тайлан
Эрсдэл хөрөнгө оруулалтын хороо 2018.6.15	<ol style="list-style-type: none"> 1. Хувьцаа гаргах ажлын явцын мэдээлэл 2. 2018 оны 1-р улирлын санхүүгийн тайлан
Эрсдэл хөрөнгө оруулалтын хороо 2018.9.04	<ol style="list-style-type: none"> 1. 2018 оны 2-р улирлын санхүүгийн тайлан, 8 сарын тойм мэдээлэл 2. 2018 оны 2-р улирлын даатгалын зах зээлийн тойм мэдээлэл 3. Хувьцаа гаргах ажлын явц 4. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд хийгдсэн ажил

Хороо, хорооны гишүүд	Шийдвэрлэсэн асуудлууд
Эрсдэл хөрөнгө оруулалтын хороо 2018.10.11	<ol style="list-style-type: none"> Дүрмийн санг нэмэгдүүлэх тухай IPO талаарх мэдээлэл Хөрөнгө оруулалтын багц
Эрсдэл хөрөнгө оруулалтын хороо 2018.12.13	<ol style="list-style-type: none"> 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 2019 оны төсөв 2016-2018 оны эрсдэлийн тайлан 2018 оны урьдчилсан санхүүгийн гүйцэтгэл
Аудитын хороо 2018.3.30	<ol style="list-style-type: none"> Далайван аудит ХХК –Аудитын тайлан Дундговь аймаг дахь салбарт хийсэн шалгалтын тайлан 2018 оны Дотоод аудитын албаны ажлын төлөвлөгөөг батлуулах
Аудитын хороо 2018.10.11	<ol style="list-style-type: none"> Дотоод аудитын албаны 2018 оны эхний 3 дугаар улиралд хийсэн ажлын товч тайлан Хувьцаат компани болж өөрчлөгдөж байгаатай холбогдуулан Аудитын хорооны шинэчилсэн дүрмийг хэлэлцэх, ТУЗ-д танилцуулан батлуулах
Аудитын хороо 2018.12.13	<ol style="list-style-type: none"> 2018 оны сүүлийн хагас жилд хийсэн шалгалтын тайлан 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайлан /АСН-ийн аудитор Мөнх-Эрдэнэ/ Дотоод аудитын албаны 2019 онд хийх ажлын төлөвлөгөө Хөндлөнгийн аудитын байгууллага сонгох, батлах тухай

ТУЗ-ийн хороодын бүтэц

Гишүүд	Засаглал, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо	Эрсдэл Хөрөнгө оруулалтын хороо	Аудитын хороо
Ч.Ганхуяг	Дарга		
Б.Золбоо		Гишүүн	Гишүүн
Ч.Ганзориг		Дарга	
Г.Цогбадрах		Гишүүн	
О.Одбаяр			Дарга
Б.Гантулга	Гишүүн		
Б.Болорчимэг	Гишүүн		
З.Ариун			Гишүүн
С.Оргил			

2018

2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ,
НИЙГЭМ УЛС ТӨРИЙН БАЙДАЛ

Бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт

2010 оны үнээр зэрэгцүүлсэн




Дээрх хугацаанд 6 удаа Олон улсын валютын сангийн хөтөлбөрт хамрагдсан
1991, 1993, 1997, 2001, 2009, 2017

Монгол улсын эдийн засаг тогтворжиж 2017 онд 5.1 хувийн өсөлттэй байсан бол 2018 онд 6.9 хувийн өсөлттэй гарсан байна. 2018 онд нийт 156 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.9 тэрбум америк доллар, үүнээс экспорт 7.0 тэрбум америк доллар, импорт 5.9 тэрбум америк долларт хүрсэн

бөгөөд гадаад худалдааны тэнцэл 2017 онд 1.8 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2018 онд өмнөх оноос 726.5 (39.0 хувь) сая америк доллараар буурч, 1.1 тэрбум америк долларын ашигтай гарсан байна.


Инфляцийн түвшин улсын хэмжээнд оны эхнээс 8.1 хувь өссөн байна. Инфляцийн өсөлтөнд хүнсний бараа, орон сууц, ус, цахилгаан, хувцас, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна. Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 индекс 2018 оны 12 сард 20,076.5 нэгж болж, өмнөх сараас 24.6 нэгжээр өсч, өмнөх оны мөн үеэс 2,032 нэгжээр буурсан байна. Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2018 оны 12 сард 2.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 71.7 (2.9 хувь) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Гадаад худалдаа
(сая ам.доллар 12 сар)



(Эх сурвалж: ОУВС)

ТОП-20 индекс, сарын дундаж, нэгжээр




Төгрөгийн америк доллартай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2018 оны 12 сард 2,637.35 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар, өмнөх сараас 2.1 хувиар, юаньтай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2018 оны 12 сард 383.03 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.8

хувиар, өмнөх сараас 3.0 хувиар тус тус суларсан бол рубльтэй харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2018 оны 12 сард 39.15 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар чангарч, өмнөх сараас 0.6 хувиар суларсан байна.


Гадаад шууд хөрөнгө оруулалт

Тэрбум доллар



ОУВС-ийн хэлцлээр валютын орох урсгал

Тэрбум доллар



2019-2020 онуудад гадаад өрийн томоохон дарамт байхгүй бөгөөд Засгийн газрын гаргасан бондуудын эргэн төлөлт 2021 оноос эхлэхээр байна.

Экспортын бүтэц



2018 ОНЫ ДААТГАЛЫН
ЗАХ ЗЭЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТ



2018 онд ердийн даатгалын салбарын нийт хураамжийн орлого 175.5 тэрбум төгрөг байгаа нь манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 0.55 хувийг эзэлж байгаа ба Монгол улсын даатгалын зах зээлд цаашид хөгжих боломж, орон зай хангалттай байгааг харуулж байна.

Монголын даатгалын зах зээлд 5 төрлийн бүтээгдэхүүн салбарын нийт хураамжийн орлогын ихэнх хувийг эзэлдэг. Тайлант жилд жолоочийн хариуцлагын даатгал, хөрөнгийн

даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгал, гэнэтийн осол/эмчилгээний даатгал болон хариуцлагын даатгалын бүтээгдэхүүнүүд даатгалын зах зээлийн орлогын 82 хувийг эзэлж байсан бол өмнөх оны мөн үед эдгээр бүтээгдэхүүнүүд нь 81 хувийг эзэлж байжээ. Тиймээс цаашид иргэд, байгууллагуудын даатгалын боловсролыг нэмэгдүүлж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцэхүйц шинэ төрлийн бүтээгдэхүүн хөгжүүлэх бүрэн боломж бололцоо байна.

ДААТГАЛЫН САЛБАРЫН ХАМГИЙН ИХ ОРЛОГЫГ БҮРДҮҮЛЖ БУЙ 5 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭЛБЭР
Тэрбум төгрөг



Даатгалын компанийн хураамжийн орлого болон нөхөн төлбөр нь тухайн оны эдийн засгийн нөхцөл байдлаас шууд хамааралтай байдаг. 2017 онд ердийн даатгалын салбарын хохирлын харьцаа өмнөх онтой харьцуулахад 18 хувиар буурсан байхад Ард Даатгалын

хохирлын харьцаа 20 хувиар буурсан байна. Харин 2018 онд салбарын хохирлын харьцаа 2017 онтой харьцуулахад 15 хувиар өссөн байхад Ард Даатгалын хохирлын харьцаа өөрчлөгдөөгүй буюу 36 хувьд хадгалагджээ.

Хохирлын харьцаа



Тайлант жилд ердийн болон урт хугацааны даатгалын компаниудын хөрөнгө 261.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27 хувиар өссөн байна.

Ард Даатгал нь 2017 онд нийт хөрөнгийн хэмжээгээрээ даатгалын салбартаа эхний 7-д орж байсан бол тайлант жилд эхний 5 компанийн нэг болжээ.



Ердийн даатгалын 15 компаниуд нийт 175.55 тэрбум төгрөгийн хураамжийн орлого хуримтлуулсан бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 24.3 хувиар өссөн байна. Давхар даатгалын зардалд 54.47 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 19 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл нийт хураамжийн орлогын 31 хувийг давхар даатгалын зардалд гаргаж үлдсэн хэсгийг дотооддоо авч үлдэж байна гэсэн үг юм.

Ердийн даатгалын компаниуд даатгалын тохиолдлын улмаас нийт 57.13 тэрбум төгрөгийг 2018 онд даатгуулагч нарт төлж барагдуулсан байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28.9 хувиар өссөн байна.

Нийт нөхөн төлбөрийн дийлэнх хэсгийг буюу 81 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, тээврийн хэрэгслийн даатгал, гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгал, барилга угсралтын даатгалууд бүрдүүлж байна.

Цэвэр ашгийн хэмжээ 2018 онд 14.29 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж өмнөх оны мөн үеэс 64 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 252.85 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 59.27 тэрбум төгрөг буюу 30.6 хувиар, нийт нөөц сан 118.25 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 23.48 тэрбум төгрөг буюу 24.8 хувиар тус тус өссөн байна.


Ердийн даатгалын компаниудын нийт хураамжийн орлого



Ердийн даатгалын компаниудын давхар даатгалын зардал



Ердийн даатгалын компаниудын нийт нөхөн төлбөр



Ердийн даатгалын компаниудын нийт цэвэр ашиг

2013	3,279
2014	1,987
2015	4,597
2016	8,455
2017	8,701
2018	14,289

Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө

2013	120,777
2014	146,025
2015	139,510
2016	165,857
2017	193,580
2018	252,851

Ердийн даатгалын компаниудын нийт нөөц сан

2013	59,452
2014	64,810
2015	63,768
2016	76,273
2017	94,775
2018	118,251

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ИЛГЭЭЛТ





Галбадрахын Цогбадрах

Гүйцэтгэх захирал

Эрхэм хүндэт харилцагч, түнш байгууллагууд болон хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч та бүхэнтэйгээ энэхүү жилийн тайлангаараа учран золгож буй өдрийн мэндийг дэвшүүлье!

2018 он Ард Даатгал ХК-ийн хувьд амжилт бүтээл дүүрэн, бахархан дурьдах ажлууд ихтэй сайхан жил болж өнгөрлөө. Энэ онд бид компанийн нийт хувьцааныхаа 30 хувийг ард иргэддээ санал болгож 5.25 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр зорьж ажилласнаас 7 орчим тэрбум төгрөгийн захиалга ирж, хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа 32.7 хувиар давж биеллээ. Энэхүү нөр их ажлыг хамтран бүтээлцсэн хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд болон ИЭлСи хуулийн фирм, БДО Аудит ХХК, Далай Ван Аудит ХХК, БиДиСек ҮЦК ХК нартаа гүн талархлаа илэрхийлье. Түүнчлэн холбогдох зөвшөөрлүүдийг олгосон эрх бүхий байгууллагууд болох СЗХ-ны гишүүд, удирдлагууд болон МХБ-ийн удирдлагын багт чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байгааг минь хүлээн авна уу. Компани маань

МХБ дээр бүртгэлтэй, хувьцаа нь чөлөөтэй арилжаалагддаг болсноор нийт иргэд маань даатгалын салбарын үйл ажиллагааг илүү өргөн мэдээлэлтэйгээр мэдрэх, ирээдүйн өсөлт хөгжлийг хамтдаа бүтээн босголцох, өндөр ирээдүйтэй өсөлтийн үр шимээс хүртэх өргөн боломж бүрдэж байгаа билээ.

Түүнчлэн бид даатгалын хураамжийн орлогоо анх удаа 13 тэрбум төгрөгт хүргэж, нийт хөрөнгийн хэмжээ 21 тэрбумын босгыг алхлаа. Өөрийн хөрөнгө 11 тэрбум төгрөгт хүрсэн нь компанийн эрсдэл даах боломжийг өсгөж, даатгуулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх чадварыг ихэсгэлээ. Нийт харилцагчдын тоо өмнөх 2017 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2 дахин нэмэгдэж, олгосон нөхөн төлбөрийн хэмжээ 6 тэрбумд хүрч өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 45 хувиар өссөн байна.

Оны эцэст бид 1,649 хувьцаа эзэмшигчтэй даатгалын компани болсон нь даатгалын

зах зээлд тэлэх, хүрээгээ өргөтгөх, зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэхэд томоохон түлхэц болно гэдэгт итгэлтэй байна. Хувьцаа эзэмшигч бүр ойр дотны хүмүүсийнхээ даатгалыг өөрийн, хувьцааг нь эзэмшдэг компани руугаа чиглүүлснээр хамтын хүчээр ихийг бүтээх боломжтой гэж хардаг билээ. Олны хүч оломгүй далай.

Даатгалын компанийн ашиг бүрдүүлэгч гол хүч нь нөөц сангуудын удирдлагыг амжилттай хэрэгжүүлж хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх бөгөөд үүний хүрээнд бид

2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын орлогыг бүрдүүлэн ажиллаж чадлаа. Цаашид Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, иргэн бүр хөрөнгө оруулагч байх гэсэн алсын харааныхаа хүрээнд бид оновчтой, өгөөжтэй хөрөнгө оруулалтуудад анхааран ажилласаар байх болно.

Ингээд та бүхэн бидний 2018 онд хийж бүтээсэн ажлын дэлгэрэнгүй тайланг тухлан сонирхож, мэргэн оюун ухаандаа тунгаан толилуулахыг хүсье!

Та бүхнийг гүнээ хүндэтгэсэн,
Г.Цогбадрах

Гүйцэтгэх удирдлага

Гүйцэтгэх захирлын дэргэд захирлуудын зөвлөл долоо хоног бүр хуралдаж, өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тухай бүр шийдвэр гаргаж ажиллаж байна.


Компани өнөөдрийн байдлаар даатгалын газар, эрсдэлийн удирдлагын газар, санхүүгийн удирдлагын газар, үйл ажиллагааны газар гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын газар нь үндсэн үйл ажиллагаа буюу даатгалын гэрээний борлуулалтыг хариуцан ажилладаг ба иргэдийн болон байгууллагын даатгал, эрүүл мэндийн даатгал хариуцсан тусдаа нэгжүүдэд хуваагдан ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын газар нь давхар даатгал болон эрсдэлийн үнэлгээ, шинжилгээний нэгж, нөхөн төлбөрийн алба гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулж,

Санхүү бүртгэлийн газар нь бүртгэлийн болон төлөвлөлт тайлангийн хэлтэс гэсэн 2 нэгжтэй ажиллаж байна. Үйл ажиллагааны газар нь туслах үүрэг бүхий функцуудыг удирдан чиглүүлж, зохион байгуулан ажиллаж байна. Үүнд компанийн хүний нөөц, хууль эрх зүй, хуулийн хянан нийцэл болон мэдээллийн технологийн үйлчилгээ багтдаг.

Компани хөдөө орон нутагт өөрийн 21 салбар нэгжийг ажиллуулж, даатгалын үйлчилгээг аймаг сумдад хүргэж, нөхөн төлбөрийн дуудлага, үйлчилгээг үзүүлэн ажилладаг. Компанийн үндсэн бүтцэд багтан ажиллаж буй газар, нэгж, салбараас гадна 2018 онд СЗХ-оос зөвшөөрөл авсан нийт 126 төлөөлөгч ажиллаж, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэж байна.

КОМПАНИЙН БҮТЭЦ



Орлог
Тайлан

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

Орлог
Тайлан

Даатгалын газар 2018 онд нийт хураамжийн орлогоо 13 тэрбум төгрөг буюу өмнөх оны үзүүлэлтээс 25.6 хувиар өсгөн ажиллаж чадсан амжилт бүтээлээр дүүрэн жил болж өнгөрлөө. Энэ нь даатгалын салбарын 9 орчим хувьтай тэнцэх үзүүлэлт бөгөөд компанийн зах зээлд эзлэх хувь ч тодорхой хэмжээнд дээшилж, байр суурь бэхжиж байгаагийн илрэл билээ.

Санхүүгийн зах зээлийн тулгуур гурван салбар бол мөнгөний зах зээл буюу банк, үнэт цаасны зах зээл, даатгалын зах зээл юм. Нийт санхүүгийн зээлд энэ гурван зах зээлийн оролцоо тэнцүү байвал санхүүгийн зэх зээл зөв зохистой хөгжиж байна гэж үздэг. Манай улсын хувьд даатгалын зах зээлийн нийт санхүүгийн зах зээлд эзлэх хувь дөнгөж 2 хувьтай байна. Энэ нь даатгалын зах зээлд улам илүү өсөх хөгжих боломж байгааг харуулж байна. Энэ өсөлт хөгжлийн баталгаа нь жил бүр даатгалын салбарын нийт хураамжийн орлогын өсөлтөөс харагддаг. Ард Даатгал ХК нь энэхүү өрсөлдөөнт зах зээлд өөрийн байр суурийг хадгалсаар ирсэн бөгөөд хураамжийн орлогоо жил бүр нэмэгдүүлж ирлээ.

Байгууллагын даатгалын алба нь 2018 онд 8,7 тэрбум гаруй төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлж өмнөх оны гүйцэтгэлээс 5 хувиар давсан үзүүлэлтийг биелүүллээ.

Энэхүү өсөлтийг хангахад гол нөлөө үзүүлсэн хүчин зүйл бол цаг алдалгүй зах зээлд гаргасан даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, үнийн болон үйлчилгээний уян хатан бодлого,

борлуулалтын баг хамт олон 2018 онд амжилттай сайн ажилласны үр дүн юм.

Байгууллагын даатгалын алба нь тухайн жил зарлагдаж байгаа даатгалын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах олон тендерүүдэд оролцдог ба үүнийг дагаад тендер бэлдэх чадвар сайжирч туршлагажиж байна. 2018 онд цөөнгүй тендерт шалгарч даатгалын гэрээ байгуулсан амжилттай ажиллалаа.

Монгол орны хөгжил дэвшилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа Оюу Толгой, Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудал зэрэг томоохон төслүүд, Энержи ресурс, Монцемент, Шангри-Ла зэрэг аж ахуйн нэгж, байгууллага болон Сэргээгдэх эрчим хүч, Уул уурхай, Зам тээврийн салбаруудтай бид хамтран ажилласныг дурьдахад таатай байна.

Томоохон байгууллагын харилцагчдад даатгалын газрын зүгээс эрсдэлийн үнэлгээ, даатгал болон нөхөн төлбөрийн холбогдолтой сургалт, танилцуулга хийж харилцагчийг халамжлах арга хэмжээнд нийт 300 гаруй сая төгрөг зарцууллаа.

Иргэдийн даатгалын алба нь Улаанбаатар хот болон орон нутгийн 24 салбар нэгж, 6 банк, 19 брокер, 13 банк бус санхүүгийн байгууллагын даатгалын төлөөлөгчдөөрөө дамжуулан 2018 онд 4.9 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлогыг төвлөрүүлсэн нь өмнөх жилээс 74 хувиар өссөн амжилтыг үзүүлээ. Иргэдийн даатгалын орлого нь компанийн нийт даатгалын хураамжийн орлогын 38 хувийг

Бүтээгдэхүүний орлогод эзлэх хувь

	2017 он	2018 он	Өөрчлөлт(%)
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	1,100.57	1,641.43	0.49
Хөрөнгийн даатгал	4,236.46	3,027.18	(0.29)
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,326.78	2,381.37	0.79
Ачааны даатгал	226.70	103.17	(0.54)
Барилга угсралтын даатгал	450.59	1,555.59	2.45
Газар тариалангийн даатгал	42.83	44.91	0.05
Мал амьтдын даатгал	113.39	285.67	1.52
Агаарын хөлгийн даатгал	33.70	-	(1.00)
Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	51.64	62.02	0.20
Хариуцлагын даатгал	500.37	979.89	0.96
Санхүүгийн даатгал	12.07	71.23	4.90
Зээлийн даатгал	473.21	403.81	(0.15)
Итгэлцлийн даатгал	3.07		(1.00)
Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал			-
Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			-
Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	2.88		(1.00)
Жолоочийн хариуцлагын даатгал	1,780.87	2,445.14	0.37
Нийт орлого	10,355.13	13,001.38	0.26

эзэлж байна. Энэхүү өсөлтөнд даатгалын зуучлагч байгууллагууд болох брокер, банкуудын оролцоо чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд 2018 онд IPO амжилттай хийж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон нь иргэдийн даатгалын борлуулалтанд мөн сайнаар нөлөөлж иргэдтэй байгуулсан гэрээний тоо даруй 20,000-аар нэмэгдсэн байна.

Даатгал өндөр хөгжсөн орны даатгалын борлуулалтын дийлэнх хувь нь даатгалын зуучлалаар дамжуулан хийгддэг бөгөөд иргэдийн даатгал, байгууллагын даатгалын борлуулалтын харьцаа ойрхон байх нь зохистой гэж үздэг. Энэ хүрээнд бид даатгалын зуучлагч байгууллагуудын хамтын ажиллагаа, Банкшурансын бүтээгдэхүүн, хамтын ажиллагаанд өндөр ач холбогдлыг өгч бүтээгдэхүүний сайжруулалтыг хийж, харилцагчийг халамжлах ажлыг дэмжин ажилласан болно.

Банкашурансийн хувьд Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Капитрон банк, Улаанбаатар хотын банкуудтай хамтран банкны бүх салбар нэгжүүдээр дамжуулан даатгалын бүх төрлийн

бүтээгдэхүүнийг борлуулж байгаа нь иргэдэд банкны соёл, тав тахтай орчинд нэг цэгийн үйлчилгээ авах харилцагчийн цагийг хэмнэх боломжоор хангаж байна. Мөн Хаан банк, Төрийн банк болон салбарын төлөөлөгчдөөр дамжуулан малчдад малын индексжүүлсэн даатгалыг улс орон даяар бусад 8 даатгалын компанитай хамтран борлуулж байна. Манай компани 2018 онд өмнөх жилээс даатгалын хураамжийн орлогыг 142 хувиар нэмэгдүүлсэн нь зах зээлийн дундаж өсөлтөөс 3 дахин өндөр үзүүлэлт юм. Энэ нь сүүлийн 3 жилийн хугацаанд малын индексжүүлсэн даатгалын зах зээлийн өсөлтөөр салбартаа тэргүүлэн амжилттай ажилласныг харуулж байна.

Даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлэгч брокер компаниудын хувьд 2018 онд нийт 19 брокертой хамтарч ажиллаж, хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн байгуулсан бөгөөд мөн харилцагчийн халамжийг дэмжин ажилласны үр дүнд даатгалын хураамжийн орлого өмнөх жилээс 100 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөнд Смарт брокерс ХХК, Сүрэг харацай ХХК, Монгол бичээч ХХК-ууд онцгой үүрэг гүйцэтгэж брокерын орлогын 68 хувийг оруулсан байна.

НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТАЙЛАН


Иргэдийн даатгалын борлуулалтын сувгийн хураамжийн орлого /сая.төгрөг

	2017 он	2018 он	Өсөлтийн хувь
Шууд борлуулалт	801.3	1,005.8	25.5%
Банкны зуучлалаар	1,236.4	1,689.9	36.7%
Даатгалын зуучлагч байгууллагаар	652.0	1,348.7	106.9%
ББСБ-ын төлөөлөгчид		571.5	
Малын Индексжүүлсэн Даатгал	122.8	298.0	142.7%
Нийт	2,812.5	4,914.0	74.7%

Бид 2018 онд 4,329 даатгуулагчийн 6 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлж, даатгалын гэрээний үүргээ бүрэн биелүүллээ. 2018 онд нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо нь өмнөх оны мөн үеэс 27 хувь, олгосон нөхөн төлбөрийн дүн 16.3 хувиар тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд манай компани давхар даатгалын компаниудтай амжилттай хамтран ажиллаж нийт хохирлын 39.84 хувь буюу 2.4 тэрбум төгрөгийг давхар даатгагчаар төлүүлж үлдсэн хэсгийг өөрийн нөөц сангаас төлсөн.


Нийт нөхөн төлбөр
/сая.төг/



Даатгалын салбарын хэмжээнд дундаж хохирол төлөлтийн харьцаа 38.9 хувь байсан

бол Ард Даатгалын хувьд хохирол төлөлтийн харьцаа 36.3 хувь байна.

Нэгж нөхөн төлбөр
/сая.төг/



2018 оны хувьд нэгж хохирлын хэмжээ 1.39 сая төгрөг болж дунджаар өмнөх оноос 190 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Жил ирэх тусам дундаж хохирлын хэмжээ өсч байгаа нь хохирлын хамрах хүрээ нь их болсон, иргэдийн даатгалын боловсрол нэмэгдсэн, нийгмийн нөлөө их, бараа бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний үнийн өсөлт зэрэг шалтгаанууд нөлөөлж байна.

Ард Даатгалын ослын дуудлагын шуурхай алба даатгуулагчиддаа 365 хоногт 24 цагийн үйлчилгээ үзүүлж, тайлант хугацаанд бид 500 мянган төгрөг хүртэлх нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийн хугацааг ажлын 3 өдөр болгож буурууллаа. Цаашид даатгуулагчдын цагийг хэмнэн интернэт орчинд ашиглах боломжтой нөхөн төлбөрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх

цахим программ үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Цагаан сар, Үндэсний Их баяр наадмыг угтан 500,000 төгрөгөөс доош үнийн дүнтэй хохирлыг ӨДӨРТ НЬ шийдвэрлэж ажилласан нь даатгуулагч, харилцагчдын талархлыг хүлээж байна. Шуурхай алба тайлант хугацаанд 2,964 дуудлага хүлээн авснаас ослын газарт баталгаажуулсан 1,884 тохиолдол, хөдөлсний дараа үзлэг хийгдсэн болон хоорондоо тохиролцсон 818, цагдаа болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагын тодорхойлолт дүгнэлтээр шийдүүлсэн 952, орон сууцны хохирлыг тодорхойлох 79 тохиолдолд даатгалын зөвлөгөө өгч ажилласан байна.

Бүтээгдэхүүний төрлөөр нөхөн төлбөрийг харуулбал:



Манай нийт нөхөн төлбөрийн 37.8 хувийг Барилга угсралтын даатгалын бүтээгдэхүүний нөхөн төлбөр эзэлж байгаа ба үүний 80 хувийг давхар даатгагч хариуцсан байна.

Энэхүү үзүүлэлт нь бид эрсдэлээ сайн тараан байршуулж, харилцагчиддаа давхар даатгалын нөхөн төлбөрийг амжилттай хүргэж, олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлж буйг илтгэж байна.

Татгалзсан нөхөн төлбөр


Даатгалын тухай хуулийн 8.5-д даатгагч нөхөн төлбөрийг бүрэн буюу түүний зарим хэсгийг олгохоос татгалзах үндэслэлтэй байдаг ба уг үндэслэл болон гэрээний дагуу олгохгүй байх тохиолдлууд гардаг. 2018 онд манай компани нийтдээ 6,000 даатгалын тохиолдлыг шалгаж 500 тохиолдлын нэхэмжлэлийг олгохоос татгалзсан ба энэ нь нийт нөхөн төлбөрийн 1 хувь юм.

Олгохоос татгалзсан тохиолдлуудын 10 орчим хувь нь даатгуулагч санаатайгаар хуурамч тохиолдол бий болгож, хууран мэхлэх сэдэлтэй

байсанг манай нөхөн төлбөрийн албаны ажиллагааны үр дүнд илрүүлэн татгалзсан.

Даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсан шийдвэртэй холбогдуулан 6 даатгуулагчаас Санхүүгийн Зохицуулах Хороонд гомдол гаргаж, Хорооноос 3 даатгуулагчид нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй гэж үзсэн ба даатгалын нөхөн төлбөртэй холбоотой нэг гомдол шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа нь нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь хууль зүйн дагуу явагдаж буйг илтгэнэ.

Бүтээгдэхүүний төрлөөр давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийг харуулвал:





ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Эрсдэл хүлээн авч түүнээс боломж бий болгох нь бизнес эрхлэгчдийн амжилтанд хүрэх хүчин зүйлсийн салшгүй нэг хэсэг билээ. Даатгалын бизнесийн хувьд бид харилцагчдын даатгаж болохуйц эрсдэлүүдийг нэгтгэн хүлээн авч *их тооны хууль*-д үндэслэн математик загварчлал ашиглан эрсдэлээ удирдаж, боломжийг бий болгодог.


Тайлант 2018 онд бид эрсдэлийн удирдлагын чиглэлээр тодорхой алхамуудыг амжилттай хийсний үр дүнд дараах үзүүлэлтүүдэд ахиц дэвшил гарсан байна.



1.АНДЕРРАЙТИНГ

Ердийн даатгалд андеррайтинг нь даатгах эрсдэлийг тооцож, хянах үйл ажиллагааг хэлнэ. Үүнд даатгалын хураамжийн зохистой байдал, даатгалд хамруулах нөхцөл, даатгалын багц дахь эрсдэл зэргийг үнэлэх үйл ажиллагаа хамаарна.

Даатгалын андеррайтингийн үйл ажиллагааг үнэлэх гол үзүүлэлтүүд нь хохирлын болон зардлын харьцаанууд юм.




2018 онд хосолсон харьцаа буурч 88 хувийн зохистой түвшинд хүрсэн нь андеррайтингийн

хяналт, удирдлага сайжирсан болон эдийн засгийн өсөлттэй холбоотой

2.НӨӨЦ САН

Нөөц сан нь төлбөрийн чадварын үзүүлэлтийг илтгэдэг гол үзүүлэлтүүдийн нэг билээ.

Сүүлийн 3 жилийн нөөц сангийн өсөлт дараах байдалтай байна.



$\text{Нөөц сан} = \text{Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан}$
 +Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан
 +Учирч болзошгүй хохирлын нөөц сан
 +Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан
 +Тусгай нөөц сан


Нөөц сан нь 2017 онд өмнөх оноос 27.65 хувиар өссөн бол 2018 онд өмнөх оноос 52.35 хувиар өсчээ. Энэхүү өсөлт нь даатгалын хураамжийн орлогын өсөлт, нөхөн төлбөрийн өсөлт болон

компанийн зах зээлд эзлэх байр сууриа өсгөх бодлоготой холбоотой. Энэхүү өсөлтийн хэмжээгээр компанийн төлбөрийн чадвар мөн өсдөг.


3. ТӨЛБӨРИЙН ЧАДВАР

Даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн төлбөрийн чадвар нь зохих түвшинд хангагдсан үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд эсэхийг төлбөрийн чадварын үзүүлэлт болон хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэх, эздийн өмчийн хэмжээ мөн илэрхийлнэ.

Эздийн өмч
/Тэрбум төгрөг/



Төлбөрийн чадвар
/%/



2018 онд хувьцаат компани болсноор эздийн өмч 2 дахин нэмэгдэж, компанийн эрсдэл даах чадвар мөн хэмжээгээр өссөн байна. Сүүлийн

3 жилийн турш төлбөрийн чадварын зохих түвшинг хангаж ажиллажээ.

4. ДАВХАР ДААТГАЛ

Манай компани 2003 оноос Англи, Америк, Герман, Япон, Сингапур, ОХУ зэрэг олон орны давхар даатгалын томоохон компаниудад даатгуулж ирсэн арвин туршлагатай билээ.

2018 оны хувьд 1,319,237.93 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий гэрээний хариуцлагаа 3.2 тэрбум төгрөгийн хураамжтайгаар давхар даатгалын томоохон компаниудад даатгуулжээ.

Бид тухайн даатгалын зүйл болон гэрээний хувьд хамгийн сайн тохирох давхар даатгалын хамгаалалтыг сонгохыг хичээж ажилладаг бөгөөд 2018 оны хувьд фронтинг давхар даатгалаас гадна трити, факультатив гэрээний хамгаалалтуудыг авсан байна. Нийт давхар даатгалын хураамжийн 67.7 хувийг факультатив төрлийн давхар даатгал эзэлж байна.

2018 оны давхар даатгалын хураамж /Давхар даатгалын төрлөөр/

	Давхар даатгалын хураамж	Эзлэх хувь
Факультатив давхар даатгал	2,141,230,327.40	67.69%
Фронтинг давхар даатгал	997,051,634.88	31.52%
Трити давхар даатгал	25,196,508.68	0.80%
	3,163,478,470.96	100.00%

Бид сүүлийн жилүүдэд агаарын хөлгийн, ачаа тээврийн, инженерийн буюу барилга угсралтын, хөрөнгийн, бизнесийн тасалдалын, хариуцлагын, аялал жуулчлалын, газар тариалангийн, олон улсын эрүүл мэндийн зэрэг олон төрлийн даатгалын үйлчилгээндээ трити болон факультатив хамгаалалт авч байна.

2018 оны хувьд 9 төрлийн даатгалын хэлбэрээр давхар даатгалын хамгаалалт авсан ба хөрөнгийн, авто тээврийн хэрэгслийн, барилга угсралтын даатгалууд голлон нөлөөлж байна.

2018 оны давхар даатгал даатгалын бүтээгдэхүүний төрлийн хувьд

	Дүн	Эзлэх хувь
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал		
зардлын даатгал	259,242,601.37	8.2%
Хөрөнгийн даатгал	749,835,534.89	23.7%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	708,415,405.29	22.4%
Ачааны даатгал	31,090,245.47	1.0%
Барилга угсралтын даатгал	878,992,117.18	27.8%
Газар тариалангийн даатгал	38,170,185.08	1.2%
Мал амьтдын даатгал	108,349,325.68	3.4%
Хариуцлагын даатгал	389,177,725.28	12.3%
Санхүүгийн даатгал	205,330.72	0.0%
	3,163,478,470.96	100.0%



ЭРСДЭЛИЙН ХОРООНЫ
ТАЙЛАН




Эрсдэлийн Удирдлагын Хороо нь даатгуулагчаас ирүүлсэн гомдол, 2 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй, маргаан бүхий даатгалын тохиолдолд нөхөн төлбөр олгох эсэх, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу буруутай этгээдээс төлбөр буцаан нэхэмжлэх эрхийг шилжүүлэн авах эсэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх чиг үүрэгтэй хороо юм. Хороо нь Гүйцэтгэх захирал, Даатгалын газрын захирал, Санхүү удирдлагын газрын захирал, Эрсдэлийн удирдлагын газрын захирал, Дотоод аудитор, Нөхөн төлбөрийн албаны дарга гэсэн 6 хүний бүрэлдэхүүнтэй 7 хоногт нэг удаа, 2018 онд нийт 52 удаа хуралдаж 2,750,573,254 төгрөгийн нөхөн төлбөрийг олгох асуудлыг шийдвэрлэж ажиллажээ.

Даатгалын нөхөн төлбөрийн шийдвэртэй холбогдуулан 4 даатгуулагчийн гомдлыг хэлэлцэж, хоёр даатгуулагчид нөхөн төлбөр

олгохоос татгалзсан шийдвэрийг хэвээр үлдээж, нэг даатгуулагчтай харилцан тохиролцож, мөн нэг даатгуулагчийн гомдлын дагуу нөхөн төлбөрийн материалыг үргэлжлүүлэн шалгаж байна.

Мөн онд жолоочийн хариуцлагын даатгалгүй зам тээврийн хөдөлгөөнд оролцож, компанийн даатгуулагчдад 23,184,400 төгрөгийн хохирол учруулсан 5 иргэнээс холбогдох хуулийн дагуу даатгуулагчид олгосон нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх эрхийг шилжүүлэн авч, хоёр хэргийг шүүхээр шийдвэрлүүлж, эргэн төлөлтийн дүн 32 хувьтай буюу 7,437,400 төгрөг буцаан төлөгдсөн. Даатгалын гэрээнд заасны дагуу эргэн төлөгдөх нөхцөлтэй олгогдсон 373,462,897 төгрөгөөс эргэн төлөлт 10 хувьтай байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Нийгмийн хариуцлагаа ухамсарлан эерэг өөрчлөлтийг авчрахад тус болно гэдэгт хэрэгжүүлэгч Ард Даатгал ХК нь 2018 онд тус гүнээ итгэн жил бүр нийгмийн сайн сайханд зорилгынхоо хүрээнд дараах ажлуудыг хамт чиглэсэн тусламжийн аян, нийтийг хамарсан олноороо хийж гүйцэтгэлээ. Бидний хийж арга хэмжээг заавал ажлынхаа нэг хэсэг болгон хэрэгжүүлсэн сайн санааны үйл бүхэн нийгэмд ажилладаг уламжлалтай.

2018 онд бид

- ▲ Баянгол дүүргийн нярай, бага насны хүүхдийн Монна асрах төвийн хүүхдүүдэд зайлшгүй хэрэгцээтэй гутал, хувцас, тоглоом зэргийг ажиллагсад өөрсдийн дотоод нөөц бололцоогоороо цуглуулан хандивлалаа.
- ▲ Ажиллагсад санаачлан Цагаан сарын битүүний өглөө Чингэлтэй дүүргийн ТҮК-ийн ажилчдад халуун аарц, хоол, цай бэлтгэн өгч, сэтгэлийн дэм өглөө.
- ▲ Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, Монголын Хөлбөмбөгийн Холбоо хамтран зохион байгуулдаг “Дуулиан-2020” 10 дахь удаагийн тэмцээнд Нийслэлийн 106, 107 дугаар сургуулийн өсвөр үеийн тамирчдыг дахин ивээн тэтгэж амжилттай оролцуулсан.
- ▲ Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Улаанбаатар Марафон-2017” бүх нийтийн гүйлтэнд манай хамт олны төлөөлөл амжилттай оролцсон.
- ▲ Монгол туургатны бөхийн барилдаан буюу Монгол, Өвөрмонгол, Тува бөхийн барилдааныг Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран ивээн тэтгэж, зохион байгууллаа. Тус барилдаанд нийт 128 бөх зодоглосон бөгөөд үзүүр, түрүү бөхчүүдийг компанийн зүгээс гарын бэлгээр урамшууллаа.
- ▲ Цус сэлбэлт судлалын үндэсний төвд ажилчид цусаа хандивлалаа.
- ▲ Баянгол дүүргийн хүүхдийн төв сувилал болон Монна хүүхдийн асрамжийн газарт нийт 11 сая төгрөгийн үнэ бүхий живх болон бусад эд хэрэглэлийг тус тус хандивлалаа.

▲ Алунгоо Эх ТББ болон Алдарт эхийн одонтой ээжүүдийн бүлгэмээс санаачлан зохион байгуулсан “Mrs World Mongolia” тэмцээнийг Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран дэмжин ажилласан. Тус тэмцээний нийт оролцогчдод санхүүгийн боловсрол олгох сургалт зохион байгуулсан бөгөөд Оюунлаг ээж номинацийн ялагчид компанийн нэрэмжит шагналыг гардуулсан.

▲ Хөгжмийн зохиолч, МУУГЗ Г.Энхбаярын тоглолтыг ивээн тэтгэн хамтран ажилласан.

▲ Дуулиан-2020 тэмцээнийг зохион байгуулагчдын санаачлан хэрэгжүүлсэн “Хариу нэхдэггүй сэтгэл” хандивын аянд Ард Даатгалын ажилчид нэгдэн ном, хувцас, тоглоом зэрэг хүүхдүүдэд хэрэгцээтэй зүйлсийг цуглуулан хандивлалаа. Тус хандив нь хотын алслагдсан дүүргүүдийн сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд тараагдаж сэтгэлийн бэлэг боллоо.

▲ Техник Технологийн Дээд Сургуулийн харьяа “Монгол Коосэн” Технологийн коллежийн оюутнуудыг улсын хэмжээний “Эй Би Юу Робокон” тэмцээнд оролцоход нь ивээн тэтгэчээр оролцон хамтран ажиллалаа. Ивээн тэтгэсэн “Моко” болон “Монтендо” багийн хүүхдүүд маань тус тэмцээнд амжилттай оролцож, ирээдүйтэй багийн шагналыг гардан авсан байна.

▲ Бизнес, улс төр, эрдэмтэн мэргэд болон иргэний нийгмийн манлайллыг оролцуулсан Монгол Улсын хөгжлийг хурдасгах эрхэм зорилготой улс төрөөс хараат бус, төрийн бус олон нийтийн байгууллага болох Монголын Эдийн Засгийн Форумын алтан хамтрагч байгууллагаар хамтран ажиллалаа. Жил бүрийн чуулга уулзалт нь Монгол улсын эдийн засаг, нийгмийн өмнө тулгамдаж буй асуудлаар нэр хүндтэй, манлайлагчдыг урин оролцуулж хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга замыг хэлэлцэн, санамж гарган, шийдвэр гаргагчдад хүргүүлдэг платформ юм.

Ард Даатгал ХК нийгмийн сайн сайханд
чиглэсэн сайн үйлсийн аяныг өрнүүлэхээс

гадна ажилчдынхаа нийгмийн асуудалд мөн
анхаарал хандуулан ажилласаар ирсэн.

2018 онд бид

- ▲ Ажиллагсдын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүд нь хөрөнгө оруулах зорилгоор ажилтан бүрт ИАЙТи ХХК-ийн 1 000 000 төгрөгийн хувьцааг эзэмших боломжоор хангасан.
- ▲ 2017 онд үр бүтээлтэй ажилласан нийт 79 ажилтанд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 50,000 ширхэг хувьцааг урамшууллын журмаар олгов.
- ▲ Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн хариуцлагын хүрээнд хоёр дахь жилдээ нийт ажиллагсадаа гэр бүлийнх нь хамтаар Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд бүрэн хамрууллаа.
- ▲ Ажиллагсдынхаа хүүхдүүдийн ирээдүйг баталгаажуулан Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааг эзэмшүүлэн хөрөнгө оруулалт хийлээ.

ХҮНИЙ
НӨӨЦ



2018 оны жилийн эцсийн байдлаар компани 98 ажиллагсадтай байгаа бөгөөд даатгалын, эрсдэлийн удирдлагын, үйл ажиллагаа, санхүү удирдлагын газар гэсэн бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт ажиллагсдын 46 хувь нь орон нутгийн салбарт ажиллаж байгаа ба хүйсийн харьцааг авч үзвэл 40 орчим хувь нь эрэгтэй бөгөөд ажилтнуудын дундаж нас нь 35 байна. Компанийн хүний нөөцийн тогтворжилтын коэффициент нь 85.9 хувь, харин гаралтын коэффициент нь 17.3 хувь байгаа нь манай компанийн ажиллагсад харьцангуй тогтвор суурьшилтай ажиллаж байгааг харуулж байна.

Компани IPO амжилттай хийсэнтэй холбоотой оны эцсээр ажиллагсаддаа компанийн хувьцааг урамшуулал хэлбэрээр хуваарилав.

Шинэ оны босгон дээр Санхүүгийн зохицуулах хорооны "Хүндэт жуух бичиг"-ээр нөхөн төлбөрийн албаны нөхөн төлбөрийн менежер Д.Ариунзул, Говьсүмбэр салбарын захирал Д.Хөгжилмаа, Сангийн яамны "Санхүү банкны тэргүүний ажилтан"-аар эрсдэлийн удирдлагын газрын захирал Ц.Тайшир, ерөнхий нягтлан

бодогч Д.Ангараг нар шагнагдаж, Монголын даатгалын холбооноос "Оны шилдэг даатгалын менежер"-ээр даатгалын менежер Л.Нэргүй, "Оны шилдэг нөхөн төлбөрийн менежер"-ээр нөхөн төлбөрийн ахлах менежер Ё.Алзахгүй, "Оны шилдэг санхүүч"-ээр Г.Баярбат нар тус тус шалгарч шагнагдлаа. 2018 оны "Шилдэг ажилтан"-аар хуульч Ж.Дамбаасүрэн, нөхөн төлбөрийн ахлах менежер Ё.Алзахгүй, нягтлан бодогч Д.Буянхишиг, шуурхай дуудлагын ажилтан А.Энхбаяр, иргэдийн даатгалын албаны дарга Ү.Мөнхсарнай нар шалгарсан байна.

2018 онд орон нутгийн ажиллагсдын зөвлөгөөнийг "Бид манлайлна" уриан дор амжилттай зохион байгууллаа.

Нийт ажиллагсдаас аттестатчлалыг 2018 оны 12 сарын 18-ны өдөр онлайн хэлбэрээр амжилттай зохион байгуулж явууллаа.


Бид сул ажлын байрыг нээлттэй бодлогын хүрээнд зарлаж, өөрийн ажиллагсдаас гадна дотоод болон гадаадын их сургуулийн төгсөгчид, мөн туршлагатай ажилгорилогчдоос хүний нөөцийн бүрдүүлэлтээ хийж байна.

2019 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ


2019 оны төсөв

Даатгалын үйл ажиллагаа
Хураамжийн орлого **+25%**

Орлого /сая.төгрөг




Нөхөн төлбөр, Давхар даатгал /сая.төгрөг



2019 оны төсөв

Хөрөнгө оруулалтын орлого **+24%**
Цэвэр ашиг **+60%**

Зардал /сая.төгрөг




Хөрөнгө оруулалтын орлого, Цэвэр ашиг /сая.төгрөг



2019 оны төсөв

Санхүүгийн үзүүлэлтүүд


Хөрөнгө /сая.төгрөг



Хөрөнгийн өгөөж /хувиар



Хөрөнгийн өгөөж /хувиар



Орлого үр дүнгийн тайлан /сая.төгрөг

Үзүүлэлт	2017	2018	2019T	Дүн	Хувь
Нийт хураамжийн даатгал	10,355	13,001	16,220	3,219	24,8%
Давхар даатгал	3,302	3,163	3,598	435	13,7%
Цэвэр хураамжийн даатгал	6,912	9,609	12,414	2,805	29,2%
Орлогод тооцсон хураамж	6,029	8,075	10,650	2,575	31,9%
Цэвэр нөхөн төлбөр	2,511	3,488	4,313	825	23,7%
Хөрөнгө оруулалтын орлого	1,400	1,757	2,183	426	24,3%
Үйл ажиллагааны зардал	3,793	4,976	5,800	824	16,6%
Цэвэр ашиг	1,124	1,263	2,018	755	59,8%

Санхүүгийн байдлын тайлан /сая.төгрөг

Үзүүлэлт	2017	2018	2019T	Дүн	Хувь
Нийт эргэлтийн хөрөнгө	9,687	19,873	22,947	3,101	15,6%
Нийт эргэлтийн бус хөрөнгө	2,040	1,130	455	-675	-59,7%
НИЙТ ХӨРӨНГӨ	11,727	21,003	23,430	2,427	11,6%
Өр төлбөр	930	1,814	2,211	397	21,9%
Нөөц сан	5,560	8,470	9,247	777	9,2%
Эздийн өмч	5,237	10,719	11,972	1,253	11,7%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ	11,727	21,003	23,430	2,427	11,6%

2018 ОНЫ АУДИТЛАГДСАН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АРД ДААТГАЛ” ХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санал дүгнэлт

Бид 2018 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Ард Даатгал” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Ард Даатгал” ХК -ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан даатгалын багц дүрмийн дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг

хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Гэхдээ бид энэхүү асуудлын талаар ямар нэг баталгаа илэрхийлэхгүй. Харин 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар доорх асуудлыг аудитын гол асуудал болгон оруулсан.

1. Ард Даатгал ХХК-ийн дүрмийн сан нь нэг бүр нь 2,345 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,492,537 ширхэг хувьцаанаас бүрдэж байсан. Хувьцаа эзэмшигчдийн

хурлын 2018 оны 4 сарын 20-ны өдрийн 04/18 тоот тогтоолоор хувьцааны үнэнд жижигрүүлэлт хийж нэг бүр нь 200 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 17,500,000 ширхэг хувьцаа болгон өөрчилсөн. Тайлангийн хугацаанд шинээр хувьцаа гаргаж (Initial Public Offering хийх) олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох, дүрмийн сангийн 30 хувьтай тэнцэх 7,500,000 ширхэг хувьцаа шинээр гаргаж олон нийтэд худалдаалах ажлуудыг зохион байгуулсан.

Олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох үйл ажиллагааг компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулж эрх бүхий байгууллагуудад хүсэлтээ гаргаснаар Монголын Хөрөнгийн Биржийн 2018 оны 6 сарын 13-ны өдрийн мэдэгдэл, Монгол улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 276 дугаар тогтоолоор тус тус хувьцаа гаргах үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн.

Аудитаар IPO хийхтэй холбоотой хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр, Монголын Хөрөнгийн Бирж болон Санхүүгийн Зохицуулах хороо зэрэг эрх бүхий байгууллагуудын

шийдвэртэй танилцсан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг

нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох

бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.

- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.



Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээллэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

**2019 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 15-НЫ ӨДӨР**

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2018.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
ХӨРӨНГӨ			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	5.1.	315,828.3	793,305.9
Хөрөнгө оруулалт	5.2.	14,371,951.3	5,910,239.1
Даатгалын авлага	5.3.	1,177,362.8	885,059.7
Бусад санхүүгийн хөрөнгө	5.4.	1,388,860.6	979,180.4
Бусад санхүүгийн бус хөрөнгө	5.5.-5.6	502,072.0	171,587.4
Даатгалын хөрөнгө	5.7.	2,117,279.1	954,708.3
Өмч, барилга, тоног төхөөрөмж -цэвэр	5.8.	1,129,789.2	2,032,555.8
НИЙТ ХӨРӨНГӨ		21,003,143.3	11,726,636.6
ӨР ТӨЛБӨР			
Даатгалын өр төлбөр	5.9.	1,315,097.4	602,089.6
Бусад санхүүгийн өр төлбөр	5.10.	350,174.0	137,186.2
Бусад санхүүгийн бус өр төлбөр	5.11.	148,682.8	190,630.3
Нөхөн төлбөрийн нөөц сан:			
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	5.12.	6,178,177.5	3,894,943.5
Учирсан боловч мэдэгдээгүй ХНС	5.12.	931,487.4	531,497.5
Мэдсэн боловч төлөөгүй ХНС	5.12.	103,592.5	29,825.3
Учирч болзошгүй ХНС	5.12.	615,268.5	462,073.0
Тусгай нөөц сан	5.12.	641,252.8	641,252.8
Нийт нөөц сан		8,469,778.6	5,559,592.1
Нийт өр төлбөр		10,283,732.9	6,489,498.2
Өөрийн хөрөнгө			
Энгийн хувьцаа	5.13.	5,000,000.0	3,500,000.0
Нэмж төлөгдсөн капитал	5.13.	3,280,854.5	
Хуримтлагдсан ашиг	5.13.	2,438,556.0	1,737,138.4
Нийт өөрийн хөрөнгө		10,719,410.5	5,237,138.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		21,003,143.3	11,726,636.6

ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тодруулга	2018.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Даатгалын үйл ажиллагаа			
Даатгалын хураамжийн орлого	5.14.	13,001,384.8	10,355,127.0
Даатгалын хураамжийн буцаалт	5.14.	(228,468.2)	(141,380.6)
Давхар даатгалын хураамжийн зардал	5.14.	(3,163,478.5)	(3,451,925.3)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	5.14.	9,609,438.2	6,761,821.1
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	5.15.	(2,283,234.0)	(882,942.4)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	5.15.	749,049.4	150,071.9
Орлогод тооцсон хураамж	5.15.	8,075,253.6	6,028,950.6
Нөхөн төлбөрийн зардал	5.16.	(6,012,374.1)	(4,063,124.2)
Давхар даатгагчийн төлсөн нөхөн төлбөр	5.16.	2,395,056.6	1,529,573.5
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	5.16.	129,451.4	22,681.7
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	5.16.	(3,487,866.1)	(2,510,869.0)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	5.17.	(473,757.2)	(157,667.4)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	5.17.	(16,645.1)	20,749.0
Учирч болзошгүй хохирлын нөөцийн сангийн өөрчлөлт	5.17.	(153,195.5)	(163,797.5)
Зардалд тооцсон нөхөн төлбөр	5.17.	(4,131,464.0)	(2,811,584.9)
Даатгалын гэрээний зардал	5.18.	(1,441,187.6)	(916,655.3)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	5.19.	116,864.3	128,250.7
Хөрөнгө оруулалтын олз, гарз	5.20.	1,756,925.5	1,405,454.1
Даатгалын үйл ажиллагааны ашиг/(алдагдал)		4,376,391.8	3,834,415.2
Ажиллагсадтай холбоотой зардал	5.21.	(1,811,035.8)	(1,423,675.8)
Үйл ажиллагааны бусад зардал	5.22.	(1,517,643.7)	(1,199,783.7)
Үйл ажиллагааны бусад орлого	5.23.	133,723.4	312,927.5
Үйл ажиллагааны бус орлого	5.24.	417,421.7	97,839.3
Үйл ажиллагааны бус зардал	5.25.	(206,303.6)	(251,923.1)
Санхүүгийн орлого/(зардал)	5.26.	(5,747.1)	(109,769.6)
Бусад ашиг/(алдагдал)		(2,989,585.2)	(2,574,385.4)
Татвар төлөхийн өмнөх ашиг/(алдагдал)		1,386,806.7	1,260,029.8
Орлогын албан татварын зардал	5.27.	(123,403.2)	(136,057.9)
Татварын дараах ашиг/(алдагдал)		1,263,403.5	1,123,971.9

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувьцаат капитал мянган төгрөг	Нэмж төлөгдсөн капитал мянган төгрөг	Хуримтлагдсан ашиг (алдагдал) мянган төгрөг	Нийт мянган төгрөг
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,500,000.0		742,506.8	4,242,506.8
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа				
Залруулагдсан үлдэгдэл	3,500,000.0		742,506.8	4,242,506.8
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)			1,123,971.9	1,123,971.9
Дахин үнэлгээний нэмэгдлийн өсөлт, (бууралт)				
Зарласан ногдол ашиг			(129,340.3)	(129,340.3)
Хувьцаат капиталын өсөлт, бууралт				
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,500,000.0		1,737,138.4	5,237,138.4
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа				
Залруулагдсан үлдэгдэл	3,500,000.0		1,737,138.4	5,237,138.4
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)			1,263,403.5	1,263,403.5
Зарласан ногдол ашиг			(561,985.9)	(561,985.9)
Хувьцаат капиталын өсөлт, бууралт	1,500,000.0	3,280,854.5		4,780,854.5
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,000,000.0	3,280,854.5	2,438,556.0	10,719,410.5

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2018.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	15,908,748.8	15,869,186.9
Даатгалын хураамжийн орлого	10,080,272.0	8,424,783.9
Давхар даатгалын нөхөн төлбөр	2,103,441.2	1,529,573.5
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		18,014.4
Бусад мөнгөн орлого	3,725,035.7	5,896,815.1
Мөнгөн зарлагын дүн (-)	14,919,589.8	12,269,420.2
Ажиллагсад төлсөн	1,096,106.2	1,035,622.4
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	314,598.7	244,465.3
Бараа материал худалдан авахад төлсөн	151,393.7	75,805.9
Ашиглалтын зардалд төлсөн	11,423.5	32,245.6
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж	2,431,934.4	2,079,179.9
Нөхөн төлбөрт төлсөн:		
Сайн дурын даатгалын	2,281,412.8	1,457,499.2
Албан журмын даатгалын	1,071,461.6	665,855.0
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	1,089,103.9	632,654.7
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	606,340.8	300,975.5
Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр	6,754.3	55.0
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	48,169.1	43,568.5
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	460,739.1	303,571.1
Даатгалын төлбөрт төлсөн		10,500.0
Бусад мөнгөн зарлага	5,350,151.9	5,387,422.1
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	989,159.0	3,599,766.8

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

	2018.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Мөнгөн орлогын дүн (+)	9,370,800.4	734,022.6
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		2,615.0
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	8,767,654.4	233,029.2
Хүлээн авсан хүүний орлого	596,846.1	492,950.2
Хүлээн авсан ногдол ашиг	6,299.9	5,428.3
Мөнгөн зарлагын дүн (-)	15,388,449.2	3,816,295.6
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,908.1	21,722.7
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	15,379,541.1	3,794,572.9

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ**(6,017,648.8)** **(3,082,273.0)****Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**

	2018.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Мөнгөн орлогын дүн (+)	5,056,799.5	
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,056,799.5	
Мөнгөн зарлагын дүн (-)	505,787.4	129,340.3
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Төлсөн ногдол ашиг	505,787.4	129,340.3
Бусад		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	4,551,012.1	(129,340.3)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(477,477.6)	388,153.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	793,305.9	405,152.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	315,828.3	793,305.9

